



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ**

2018 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Дотоод үйл ажиллагаанд мөрдөх заавар  
батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.5.6, Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 3.1.4 дэх зорилт, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар тогтоолын 1 дэх заалтын 6 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журмын 3.1.1 болон Санхүүгийн зохицуулах хорооны стратеги төлөвлөгөө /2018-2021 он/-ний 5.1.1, 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Даатгалын салбарт эрсдэлийн удирдлагад суурилсан хяналт тавих тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор “Эрсдэлд суурилсан хөрөнгө тооцох аргачлал”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хэрэгжүүлэх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх заавар”-ыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Тушаал батлагдсантай холбогдуулан “Эрсдэлийн удирдлагад суурилсан хяналтын заавар”-ыг батлах тухай Ажлын албаны даргын 2014 оны 246 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тушаалаар баталсан аргачлал, журам, зааврыг 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.


4. Зааврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалт, зохицуулалтын газар /Б.Долгорсүрэн/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АРИУНАА

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны  
даргын 2018 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн  
297 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



## ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХӨРӨНГӨ ТООЦОХ АРГАЧЛАЛ /RISK BASED CAPITAL APPROACH/

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ аргачлал нь ердийн даатгал, урт хугацааны даатгал, давхар даатгалын компани (цаашид “даатгагч” гэх) –ийн даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэхийг тодорхойлоход оршино.

### Хоёр. Эрсдэлд суурилсан хөрөнгө (RBC) тооцох

2.1. Эрсдэл суурилсан хөрөнгийг дараах аргачлалаар тооцно.

№	Үзүүлэлт	Дүн
1	Зөвшөөрөгдөх хөрөнгө	
2	Зайлшгүй байх хөрөнгө	$2 = \sqrt{3^2 + 6^2} + 7$
3	Даатгалын эрсдэл	$3 = \sqrt{4^2 + 5^2}$
4	Хураамжийн эрсдэл	
5	Нөөц сангийн эрсдэл	
6	Зээлийн эрсдэл	
7	Үйл ажиллагааны эрсдэл	
8	RBC харьцаа	$8 = \frac{1}{2} \times 100\%$

Тайлбар: тоон утгаар илэрхийлэгдэж болох эрсдэлийн төрлийг нэмэх боломжтой.

2.2. “Зөвшөөрөгдөх хөрөнгө”-ийг Санхүүгийн байдлын тайлан дахь “Эздийн өмчийн дүн”-ээс “Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн”, “Биет бус хөрөнгө /Цэвэр/-ийн дүн” болон “Бусад хөрөнгийн дүн”-г тус тус хасаж тооцно.

2.3. “Хураамжийн эрсдэл”-ийг Даатгалын хэлбэр (цаашид даатгалын бүтээгдэхүүнээр тооцох боломжтой) тус бүрээр дараах аргачлалаар тооцно. Үүнд:

Хураамжийн эрсдэл = Даатгалын цэвэр хураамж х Хураамжийн эрсдэлийн коэффициент

Хураамжийн эрсдэлийн коэффициент =  $VaR_c(LRa)$  – Таамагласан (LRa)

Энд,

“Loss Ratio” - LRa - Хохирлын харьцаа

“Value at Risk”- VaR нь тодорхой хугацаанд гарч болох хамгийн их хохирлын хэмжээг тодорхой магадлалд харгалзуулан хэмждэг статистик арга юм.

c- итгэлцлийн түвшинг илэрхийлэх бөгөөд даатгалын хэлбэрээс хамаараад 95%, 99.0%, 99.5% гэх мэт ялгаатайгаар тооцно.

2.4. “Нөөц сангийн эрсдэл”-ийг Даатгалын хэлбэр (цаашид даатгалын бүтээгдэхүүнээр тооцох боломжтой) тус бүрээр дараах аргачлалаар тооцно. Үүнд:

Нөөц сангийн эрсдэл =  $Var_c(LRe)$  – max (3-аас доошгүй тооцсон аргаар тооцсон LRe)

Энд,

“Loss Reserve” - LRe - Хохирлын нөөц сан

“Value at Risk”- VaR нь тодорхой хугацаанд гарч болох хамгийн их хохирлын хэмжээг тодорхой магадлалд харгалзуулан хэмждэг статистик арга юм.

c- итгэлцлийн түвшинг илэрхийлэх бөгөөд даатгалын хэлбэрээс хамаараад 95%, 99.0%, 99.5% гэх мэт ялгаатайгаар тооцно.

2.5. “Зээлийн эрсдэл”-ийг дараах аргачлалаар тооцно. Үүнд:


Хөрөнгийн ангилал	Дүн	Эрсдэлийн коэффициент	Зээлийн эрсдэл (3) = (1) x (2)
	(1)		
Банкны харилцах, хадгаламж		0%	
Гадаадын банкин дахь харилцах, хадгаламж, хадгаламжийн сертификат		0%	
Дотоодын банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулсан мөнгөн хөрөнгө		5%	
Бэлэн мөнгө		0%	
Хэвийн авлага		0%	
Хугацаа хэтэрсэн авлага		25%	
Хэвийн бус авлага		50%	
Эргэлзээтэй авлага		100%	
Муу авлага		100%	
Банкны хадгаламжийн сертификат		0%	
Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл		0%	
Төв банкны үнэт цаас		0%	
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Хэвийн үнэт цаас 0%		
Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл	Хугацаа хэтэрсэн үнэт цаас 25%		
Компанийн өрийн хэрэгсэл	Хэвийн бус үнэт цаас 50%		
	Эргэлзээтэй үнэт цаас 75%		
	Муу үнэт цаас 100%		
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 1 ангилал		20%	
Монголын хөрөнгийн биржийн хувьцаат компанийн хувьцаа – 2 ангилал		30%	
Хөрөнгө оруулалтын нээлттэй сан		5%	
Хөрөнгө оруулалтын хаалттай сан		10%	
Гадаадын Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл		0%	

Гадаадын Төв банкны үнэт цаас		0%	
Гадаадын компанийн өрийн хэрэгсэл		30%	
Гадаадын компанийн хувьцаа		50%	
Давхар даатгалын хойшлогдсон хураамж		0%	
Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг		0%	
Санхүүгийн түрээс		5%	
Үл хөдлөх хөрөнгө		5%	
Хөдлөх хөрөнгө		80%	
<b>Нийт дүн</b>			

2.6. “Үйл ажиллагааны эрсдэл” нь даатгалын нийт хураамжийн 5 хувьтай тэнцүү байна.

### Гурав. Бусад

3.1. Хянан шалгагч нь Даатгагчаас ирүүлсэн улирал бүрийн санхүүгийн тайланд үндэслэн эрсдэлд суурилсан хөрөнгийг тооцож гаргана.



## ДААТГАЛЫН КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЭРСДЭЛД СУУРИЛСАН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Даатгалын тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгалын компани /цаашид “даатгагч” гэх/-ийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалт гэж дараах иж бүрэн хяналт шалгалтын үйл ажиллагааг ойлгоно:

1.2.1. Даатгагчийн талаарх тайлан, мэдээ, мэдээллийг цуглуулах;

1.2.2. Даатгагчийн үйл ажиллагаанд зайнаас хяналт /цаашид “зайны хяналт” гэх/ тавих, зайны хяналтын дүгнэлт бичих;

1.2.3. Даатгагчийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалт /цаашид “газар дээрх шалгалт” гэх/-ыг төлөвлөх, хийх;

1.2.4. Газар дээрх шалгалтын тайлан бичих.

1.3. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын зорилго нь даатгагчийн санхүү, төлбөрийн чадварын байдал, компанийн удирдлага, хяналтын орчин болон эрсдэлийн удирдлагын түвшинд үнэлэлт, дүгнэлт өгөх, даатгагчийн эрсдэлийн түвшинг тогтоох, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах буюу энэ талаарх саналаа Хорооны удирдлага /цаашид удирдлага гэх/-д танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулахад оршино.

1.4. Хорооны хянан шалгагч нь /цаашид “хянан шалгагч” гэх/ холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, зааврын дагуу даатгагчид зайны хяналт тавьж ажиллана.

1.5. Хянан шалгагч нь ажил үүргийн хуваарийн дагуу хариуцсан даатгагчтай аливаа ашиг сонирхлын зөрчилгүй, бие даасан, хараат бус байж, төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллана.

1.6. Хянан шалгагч нь эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх даатгагчийг хариуцаж ажиллахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1-д заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд энэ талаар Хорооны хяналт шалгалт хариуцсан нэгжийн даргад бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

1.7. Хянан шалгагч нь зайны хяналт болон газар дээрх шалгалтыг хийх, даатгагчийн эрсдэлийн түвшинг даатгагчид учирч болох эрсдэлийн үнэлгээ болон даатгагчийн зах зээлд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний хамаарлаар дараах томъёогоор тодорхойлно:

$$ЭТ = \sqrt{УБЭ * 33Н}, \text{ Үүнд:}$$

ЭТ- Эрсдэлийн түвшин

УБЭ - Учирч болзошгүй эрсдэлийн индекс

## ЗЗН – Зах зээлийн нөлөөллийн индекс

1.8. Учирч болзошгүй эрсдэлийн түвшинг зайны хяналт хийхдээ энэхүү журмын 3 дугаар бүлэг, газар дээрх шалгалт хийхдээ энэхүү журмын 4 дүгээр бүлэгт заасны дагуу тус тус тодорхойлно.

1.9. Даатгагчийн зах зээлд үзүүлэх нөлөөллийн индексийг энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан “Даатгагчийн зах зээлийн нөлөөллийн үнэлгээ” буюу даатгуулагчдын тоо, даатгалын компанийн салбарын тоо, даатгалын хураамжийн орлогын дүн, даатгалын бүтээгдэхүүний багцын эрсдэлийн дундаж үзүүлэлтийг ашиглан энэхүү журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу Даатгалын салбарын нэгтгэл хариуцсан ажилтан /цаашид “Нэгтгэл хариуцсан ажилтан” гэх/ тодорхойлно.

1.10. Нэгтгэл хариуцсан ажилтан даатгагч бүрээр “Даатгагчийн зах зээлийн нөлөөллийн үнэлгээ”-г гаргаж, энэхүү журмын 6 дугаар хавсралтад заасны дагуу нэгтгэлийг даатгагчдаас жилийн санхүүгийн тайланг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор гаргаж, Хорооны Хяналт шалгалт хариуцсан газарт хүргүүлнэ.

### **Хоёр. Даатгагчийн талаарх тайлан, мэдээ, мэдээллийг цуглуулах.**

2.1. Хянан шалгагч нь энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасны дагуу “Даатгагчийн хувийн хэрэг”-ийг жил бүрийн 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор дараах мэдээллийн хүрээнд хөтөлж, холбогдох тайлан, мэдээ, мэдээллийг хавсаргасан байна:

- 2.1.1. Даатгагчийн ерөнхий мэдээлэл;
- 2.1.2. Эрсдэлийн удирдлагын үнэлгээ;
- 2.1.3. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээ;
- 2.1.4. Компанийн бүтэц, зохион байгуулалт;
- 2.1.5. Мэдээллийн технологи;
- 2.1.6. Хяналтын тогтолцоо.

2.2. Хянан шалгагч нь дараах тохиолдолд “Даатгагчийн хувийн хэрэг”-т өөрчлөлт оруулах бөгөөд өөрчлөлт оруулсан талаарх мэдээллийг энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу гаргаж, “Даатгагчийн хувийн хэрэг”-т хавсаргана:

- 2.2.1. Улирал бүр зайны хяналт хийсний дараа;
- 2.2.2. Газар дээрх шалгалт хийсний дараа;
- 2.2.3. Даатгагчийн эрсдэлийн түвшин нэмэгдсэн байж болзошгүй гэж хянан шалгагч үзсэн бусад тохиолдолд.

2.3. Хянан шалгагч нь энэхүү журмын 2.1-т заасан “Даатгагчийн хувийн хэрэг”-т тусгагдсан тайлан, мэдээ, мэдээллийг дараах байдлаар хянаана:

- 2.3.1. Хууль, журамд заасан хугацаанд нь бүрэн ирүүлсэн эсэх;
- 2.3.2. Эрх бүхий албан тушаалтнууд нь тайлан, мэдээ, мэдээллийг үнэн зөв гаргасан болохыг баталгаажуулан гарын үсгээ зурж, тамга, тэмдгээ дарсан эсэх;
- 2.3.3. Тайлан, мэдээ, мэдээллийн үзүүлэлтүүдийг үнэн зөв гаргасан эсэх, тэдгээрийн уялдаа холбоо, өмнөх тайлант үеийн тайлан, мэдээний үзүүлэлтээс үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээгээр өссөн болон буурсан үзүүлэлтүүдэд тайлбар хийсэн эсэх;
- 2.3.4. Газар дээрх шалгалтын акт материалтай тохирч байгаа эсэх.

2.4. Хянан шалгагч нь даатгагчийн ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэлд нэмэлт тайлбар, тодруулга авах зорилгоор холбогдох эрх бүхий албан тушаалтнуудтай холбогдох уулзалтыг зохион байгуулж болох ба энэ тохиолдолд уулзалт зохион байгуулах тухай мэдэгдлийг уулзалтад оролцох этгээдэд хүргүүлж, уулзалтын талаарх тэмдэглэлийг энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасны дагуу боловсруулж, баталгаажуулсан байна.

2.5. Хянан шалгагч нь даатгагчийн ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл нь дутуу гэж үзвэл Даатгалын тухай хуулийн 65 дугаар зүйлд заасны дагуу нэмж ирүүлэхийг, шаардлага хангаагүй гэж үзвэл залруулахыг шаардаж болно.

## Гурав. Даатгагчийн үйл ажиллагаанд зайны хяналт хийх

3.1. Хянан шалгагч нь улирал бүр даатгагчийн үйл ажиллагаанд зайны хяналт хийж, үүнд дараах шинжилгээг зайлшгүй хэрэгжүүлсэн байна:

3.1.1. *Даатгагчийн хувийн хэрэгт орсон өөрчлөлтийг судлах.* Тухайлбал даатгагчийн санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн түвшин, хянан шалгагчийн анхаарал тавих түвшин болон бусад томоохон өөрчлөлт гарсан эсэхийг олж мэдэх;

3.1.2. *Үйл ажиллагааны нөлөөллийг судлах.* Тайлант үед гарсан томоохон өөрчлөлт нь ирээдүйд компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд нөлөөлөх эсэх талаар судлах;

3.1.3. *Санхүүгийн шинжилгээ хийх.* Хянан шалгагч нь санхүүгийн тогтвортой байдал, эрт анхааруулах шинжилгээний үзүүлэлтийг ашиглах ба Санхүүгийн шинжилгээний үнэлгээг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан “Санхүүгийн шинжилгээний үнэлгээ” хийх аргачлалаар боловсруулна. Санхүүгийн шинжилгээний үнэлгээний эрт анхааруулах шинжилгээг хийхдээ энэхүү журмын 15 дугаар хавсралтад заасан аргачлалыг ашиглана;

3.1.4. *Өмнөх үеийн тайлангуудыг судлах.* Даатгагчийн санхүүгийн үйл ажиллагаа, төлбөрийн чадвар болон өмнөх үед хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, эрсдэл хүлээн авах байдал болон онцгойлсон үйл явдлуудыг тухайлан судлах. Үүнд: Даатгагчийн санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтийн шинжилгээг энэхүү журмын 12 дугаар хавсралт, Даатгагчийн орлого, үр дүнгийн тайлангийн шинжилгээг 13 дугаар хавсралт, Даатгагчийн үйл ажиллагааны шуурхай шинжилгээг 14 дүгээр хавсралтын дагуу боловсруулна.

3.1.5. *Даатгагчийн санхүүгийн төсөв, төлөвлөгөөг хянах.* Даатгагчийн санхүүгийн төлөвлөгөө хэр бодитой хийгдсэн, мөн төлөвлөгөөнд тодорхой өөрчлөлт орсон эсэх талаар, энэ нь цаашид эрсдэл дагуулах эсэхийг хянах;

3.1.6. *Даатгагчийн бизнес төлөвлөгөөг хянах.* Даатгагчийн бизнес төлөвлөгөө нь хэр бодитой боловсруулагдсан болон бизнес төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа эсэх, мөн бизнес төлөвлөгөөг санхүүжүүлэх хэмжээний хөрөнгө даатгагчид байгаа эсэх, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай удирдлага, ажиллах хүч байгаа эсэх гээд ерөнхийд нь бизнес төлөвлөгөө хэрэгжих боломжтой эсэхийг хянах;

3.1.7. *Аудиторын тайланг хянах.* Аудиторын тайлан нь хянан шалгагчийн эрсдэлийн үнэлгээ хийх ажлын зайлшгүй нэг хэсэг нь байх ёстой.

3.2. Хянан шалгагч нь энэхүү журмын 3.1-т заасан дүн шинжилгээнд үндэслэн даатгагчид учирч болзошгүй эрсдэлийн индексийг чанарын үзүүлэлтийн үнэлгээ болон санхүүгийн үзүүлэлтийн үнэлгээ хоёрын дундаж үзүүлэлтээр тодорхойлно.

3.3. Хянан шалгагч нь энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасны дагуу даатгагчийн чанарын үзүүлэлтийн үнэлгээг дараах үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэнэ:

3.3.1. *Даатгагчийн ерөнхий үзүүлэлт:* Энэхүү үзүүлэлт нь байгууллагын болон Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/, байгууллагын удирдлагууд болон хувьцаа эзэмшигчдийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой асуудлуудыг хамруулна. Хянан шалгагч нь энэхүү мэдээллийг тогтмол болон тухай бүр даатгагчаас ирүүлдэг мэдээлэл, мөн даатгагчийн хувийн хэрэг дэх мэдээллүүдээс хариултыг олох боломжтой.

3.3.2. *Эрсдэлийн удирдлага:* Энэхүү үзүүлэлт нь компанийн эрсдэлийн удирдлага болон түүний гүйцэтгэлтэй шууд холбогдох ба компани эрсдэлээ хэрхэн илрүүлж, үнэлж байгаа процесс болон түүнийг бууруулах, хянах механизм болон хөрөнгийн хангалттай байдлыг хянаж байгаа үйл явцаас хамаарна. Хянан шалгагч нь энэхүү мэдээллийг жил бүрийн тайлан мэдээ, эрсдэлийн удирдлагын стратеги болон бусад мэдээллүүдээс олж авах боломжтой.

3.3.3. *Андеррайтингийн эрсдэл:* Энэхүү үзүүлэлт нь даатгалын хураамжийн хангалттай байдалтай холбогдоно. Хянан шалгагч нь энэхүү мэдээллийг Актуарын тайлангаас харах боломжтой.

3.3.4. *Зах зээл, хөрвөх чадвар болон зээлийн эрсдэл:* Компанийн хөрөнгө нь найдвартай, хариуцлагаа даах хэмжээний, хүлээгдэж байгаа нөхөн төлбөр болон бусад төлбөрийг төлж чадахуйц хөрвөх чадвартай байх шаардлагатай. Хөрөнгө оруулалтын бодлого нь стратеги төлөвлөгөөтэй уялдсан байх шаардлагатай төдийгүй хөрөнгийн чанар, тараан байршуулалт, төлөвлөж буй хөрөнгийн үр ашиг, хөрөнгө, хариуцлагын нийцэж буй байдал, үр дүнг хянах талаар болон хүрээлэн байгаа орчны өөрчлөлтөд хөрөнгө оруулалтыг хэрхэн зохицуулах талаар механизмыг багтаасан байх шаардлагатай. Хянан шалгагч нь хөрөнгө оруулалтын бодлогын гүйцэтгэлийг хянахдаа хөрөнгө оруулалтын ил тод гүйцэтгэсэн эсэх, хөрөнгө оруулалтын менежер нь хөрөнгө оруулалтын бодлогыг дагаж мөрдсөн эсэх болон хөрөнгө оруулалтын үр ашгийг хамгийн их байлгах чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа гэх мэтийг судална. Мөн хөрвөх чадварын эрсдэлийн тухайд компанийн удирдлага нь тогтмол бэлэн мөнгөний урсгал буюу шаардлагатай бэлэн мөнгийг байлгах тал дээр анхаарахаас гадна томоохон хэмжээний зардалд бэлэн байх ёстой. Хянан шалгагч нь энэхүү эрсдэлийг хянахдаа компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хянана. Хөрвөх чадварын талаарх мэдээллийг компанийн жил тутмын мэдээллээс авч болно. Хөрөнгө оруулалтын үр ашгийг салбарын дундаж эсвэл өрсөлдөгчийн мэдээлэл дээр тулгуурлан гаргаж, дүгнэлт хийж болно. Мөн багцын эрсдэлийг хянах шаардлагатай.

3.3.5. *Үйл ажиллагааны эрсдэл:* Энэхүү үзүүлэлт нь компани эсвэл хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны зохион байгуулалт болон үйл ажиллагааны удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаатай холбоотой. Хянан шалгагч нь даатгагчаас жил бүр ирүүлдэг мэдээллээс үйл ажиллагааны эрсдэлийг удирдах удирдлагын чадварыг тодорхойлж болно.

3.3.6. *Давхар даатгал:* Энэхүү үзүүлэлт нь компанийн давхар даатгалын стратеги, хэрэгжилт, хяналт болон давхар даатгалтай холбоотой хязгаарлалтаас хамаарна. Давхар даатгал нь эрсдэлийг бууруулах хэрэгсэл, гэвч түүнийг тохиромжтойгоор ашиглахгүй бол эрсдэлийг бий болгох, нэмэгдүүлэх эрсдэлтэй. Хянан шалгагч нь энэхүү мэдээллийг компанийн давхар даатгалын удирдлагатай холбоотой тогтмол ирүүлж байдаг мэдээллээс олж авч болохоос гадна газар дээрх хяналт шалгалтын үеэр давхар даатгалын гэрээнүүдийг мөн хянаж үздэг.

3.3.7. *Группийн эрсдэл:* Энэхүү үзүүлэлт нь компанийн нэгдэл доторх компаниудын үйл ажиллагаануудаас үүдэн бий болж байдаг. Хянан шалгагч нь энэхүү мэдээллийг хувьцаа эзэмшигч хоорондын мэдээллээс олж авч болно. Жилийн тайлангаас мөн байгууллага, гэрээнүүдтэй холбоотой болон группийн эрсдэлийн удирдлагатай холбоотой мэдээллүүдээс авч болно.

3.3.8. *Хэрэглэгч, зах зээл болон бүтээгдэхүүн:* Энэхүү үзүүлэлт нь даатгагчийн хэрэглэгчээ тодорхойлох болон тэдгээрт зориулсан өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн нийлүүлэх чадварыг үнэлнэ. Хянан шалгагч нь даатгагчийн бодлогын баримт бичиг болон танилцуулах хуудаснаас энэ талаарх мэдээллийг авах боломжтой бөгөөд стратегийн баримт бичигт компанийн давуу болон сул талыг тодорхойлон бичсэн байдаг. Мөн жил бүрийн тайлан, мэдээнд эдгээр эрсдэлийг удирдах талаар тусгасан байдаг.

3.4. Хянан шалгагч нь даатгагчийн санхүүгийн үзүүлэлтийн үнэлгээг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан санхүүгийн шинжилгээний үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэнэ:

3.5. Даатгагчийн санхүүгийн чадварын үзүүлэлт нь компанийн хөрөнгийн чадвартай уялдахаас гадна даатгалын нөөц сангийн хүртээмжтэй, хангалттай байдлаас шалтгаална. Хянан шалгагч нь актуарын болон санхүүгийн мэдээллийг даатгагчийн тогтмол ирүүлдэг мэдээлэл болон улирал, жилээр ирүүлдэг мэдээллээс олж авах боломжтой, түүнчлэн зарим



тохиолдолд даатгагчийн санхүүгийн чадвар болон зарим үзүүлэлт буурсан тохиолдолд нэмэлтээр шаардаж авсан мэдээллээс авах боломжтой.

3.6. Хянан шалгагч нь даатгагчийн эрсдэлийн түвшинг энэхүү журмын 3.2-т заасны дагуу тооцоолж, эрсдэлийн түвшингээс хамааруулан “Хянан шалгагчийн анхаарал тавих түвшин” /цаашид “анхаарал тавих түвшин” гэх/-г дараах байдлаар тодорхойлно.

3.6.1. Эрсдэлийн түвшин 1-4 хүртэл бол, анхаарал тавих түвшин “хэвийн” буюу хянан шалгагч даатгагчийн үйл ажиллагаанд улирал бүр зайны хяналтыг хэвийн хэрэгжүүлэх;

3.6.2. Эрсдэлийн түвшин 5-20 хүртэл бол, анхаарал тавих түвшин “байнгын хяналт тавих” энэхүү журмын 3.6.1-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна даатгагчийн төлөөлөлтэй уулзах, шаардлагатай тохиолдолд эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө шаардах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.6.3. Эрсдэлийн түвшин 21-50 хүртэл бол, анхаарал тавих түвшин “өөрчлөлт сайжруулалт хийх” буюу хянан шалгагч энэхүү журмын 3.6.2-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна Даатгалын тухай хуулийн 68.1.3, 68.1.4, 68.1.5-д заасан албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.6.4. Даатгагчийн эрсдэлийн түвшин 51-ээс дээш бол, анхаарал тавих түвшин “газар дээрх шалгалт хийх” буюу хянан шалгагч энэхүү журмын 3.6.3-т заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс гадна даатгагчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

3.7. Анхаарал тавих түвшин энэхүү журмын 3.6.1, 3.6.2, 3.6.3-т заасан түвшинд байгаа хэдий ч дараах нөхцөл байдал үүсвэл хянан шалгагч нь тухайн даатгагчийн хувьд анхаарал тавих түвшинг “газар дээрх хяналт шалгалт” хийх түвшин рүү шилжүүлж болно. Үүнд:

3.7.1. Энэхүү журмын 3.3-т заасны дагуу даатгагчийн чанарын үзүүлэлтийн үнэлгээг тооцоход ашигласан үзүүлэлтүүдээс хоёр ба түүнээс дээш үзүүлэлтийн хувьд эрсдэлийн үнэлгээ нь 2.5 ба түүнээс дээш бол;

3.7.2. Энэхүү журмын 3.4-т заасны дагуу санхүүгийн шинжилгээний үнэлгээг тооцоход ашигласан үзүүлэлтүүдийн 3 ба түүнээс дээш үзүүлэлтийн хувьд эрсдэлийн үнэлгээ нь 2.5 ба түүнээс дээш бол.

3.8. Хянан шалгагч нь даатгагчийн эрсдэлийн түвшинг энэхүү журмын 1.7-д заасны дагуу үнэлж, даатгагч санхүүгийн тайланг тушаасан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор энэхүү журмын 16 дугаар хавсралтад заасны дагуу зайны хяналтын дүгнэлтийг бичиж, даатгагчид хүргүүлнэ.

3.9. Хорооны Хяналт шалгалт хариуцсан нэгжийн дарга нь даатгагчдын эрсдэлийн түвшингийн үнэлгээг нэгтгэн, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэнэ.

### **Дөрөв. Газар дээрх шалгалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх**

4.1. Газар дээрх шалгалт нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

4.1.1. “Иж бүрэн шалгалт” гэж Хорооноос батлагдсан хуваарь, удирдамжийн хүрээнд даатгагчийн үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж нарийвчлан шалгаж, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхийг хэлнэ.

4.1.2. “Хэсэгчилсэн шалгалт” гэж энэхүү журмын 3.6.4-т заасны дагуу даатгагчид анхаарал тавих түвшин “газар дээрх шалгалт хийх” гэж тодорхойлогдсон, мөн даатгагч болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шүүмжлэлийн мөрөөр, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж үзэж даатгагчийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг асуудлын нэр төрөл, эрсдэлээр нь шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөхийг хэлнэ.

4.2. Хороо болон бусад эрх бүхий байгууллагын хүсэлтээр холбогдох асуудлын хүрээнд даатгагчийн үйл ажиллагаанд “Хамтарсан шалгалт”-ыг тухайн байгууллагатай хамтарч хэрэгжүүлж, үнэлэлт, дүгнэлт өгч болно.

4.3. Иж бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг Хорооны даргын тушаалаар, хамтарсан шалгалтыг холбогдох байгууллагын удирдлагатай хамтарсан тушаалаар баталсан удирдамжийн дагуу шалгалтын ажлын хэсэг хэрэгжүүлнэ.

4.4. Шалгалтын ажлын хэсэг шалгалт эхлэхээс өмнө даатгагчийн удирдлагад шалгалтын удирдамжийг хүргүүлэх бөгөөд удирдлагад дараах зүйлсийг танилцуулсан байна. Үүнд:

- 4.4.1. Шалгалтын зорилго, үндэслэл;
- 4.4.2. Шалгалтын төрөл;
- 4.4.3. Шалгалт үргэлжлэх хугацаа;
- 4.4.4. Шалгалтын ажлын хэсэг, шалгалтын ажлын хэсгийн ахлагч;
- 4.4.5. Шалгалтын хамрах хүрээ, асуудлууд;
- 4.4.6. Шаардлагатай баримт бичгүүдийн жагсаалт;
- 4.4.7. Шалгалтын тайланг танилцуулах.

4.5. Хянан шалгагч нь газар дээрх шалгалтыг хэрэгжүүлэхээс өмнө шалгалт хийх бэлтгэл ажлыг ханган энэхүү журмын 9 дүгээр хавсралтад заасан маягыг бөглөсөн байх шаардлагатай.

4.6. Хянан шалгагч нь зайны хяналт болон энэхүү журмын 4.4-т заасан мэдээллийг олж авсан эх үүсвэрийг бататгах, тодруулга авах зорилгоор даатгагчийн удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалтыг зохион байгуулж болно. Үүнд:

4.6.1. Компанийн эрх бүхий албан тушаалтантай уулзаж, дараах асуудлуудыг тодруулж болно.

4.6.1.1. Компанийн үйл ажиллагаа, бизнесийн гол хэлбэр болон компанийн засаглалд гарсан томоохон өөрчлөлтүүд

4.6.1.2. Хорооноос өгсөн үүрэг даалгавар, Хөндлөнгийн актуарч, аудиторын, дотоод аудиторын өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлсэн ажлын тайлангийн талаар

4.6.1.3. Даатгагч төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангахад хамгийн ихээр нөлөөлдөг ач холбогдол бүхий үйл ажиллагаа, чиглэлийн талаар тодруулах;

4.6.1.4. Бусад шаардлагатай гэж үзсэн асуудлын талаар.

4.6.2. Даатгалын тухай хуулийн 39.1-т заасны дагуу актуарчаар ажиллах эрх авсан компанийн хөндлөнгийн актуарчтай уулзаж, дараах асуудлуудыг тодруулна.

4.6.2.1. Бизнесийн төрөл болон үндсэн шинж чанар, хохирол хөгжүүлэлт болон давхар даатгал зэргийн материаллаг байдлын талаар;

4.6.2.2. Даатгалын нөөц сан, эрсдэлийн удирдлага болон даатгалын эрсдэлүүдийн талаар;

4.6.2.3. Актуарчийн мэргэжлийн чадвар, нэр хүнд болон даатгалын компанитай үүсгэсэн харилцаа холбоо;

4.6.2.4. Өмнөх шалгалтад ашигласан арга аргачлал болон таамаглалд ямар нэг өөрчлөлт гарсан эсэх;

4.6.2.5. Актуарчийн дотоод болон гадаад аудитортой холбогдох харилцаа холбоо;

4.6.2.6. Бусад шаардлагатай гэж үзсэн асуудлын талаар.

4.6.3. Даатгалын тухай хуулийн 33.2-т заасан шаардлагыг хангасан хөндлөнгийн аудитортой уулзаж, дараах асуудлуудыг тодруулж болно.

4.6.3.1. Даатгагчийн даатгалын үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, давхар даатгал болон үүсэж болзошгүй эрсдэлийн талаар;

4.6.3.2. Аудиторын мэргэжлийн чадвар, нэр хүнд болон даатгалын компанитай үүсгэсэн харилцаа холбоо;

4.6.3.3. Хөндлөнгийн аудитор нь дотоод аудитортой холбогдох харилцаа холбоо;

4.6.3.4. Бусад шаардлагатай гэж үзсэн асуудлын талаар.

4.6.4. Дотоод хяналтын үйл ажиллагаа (Дотоод хяналтын үйл ажиллагаа, үр ашигтай байдлын тухай, бүртгэл, түүний үйл явц, нэгтгэлтэй холбоотой байгууллагын чадваруудтай

хамаарах үйл ажиллагааны тухай, мөн санхүүгийн мэдээллийн тайлагнал нь санхүүгийн тайланд бодитойгоор үндэслэсэн эсэх эсвэл эдгээр мэдээлэлд худал мэдээлэл байсан эсэх зэрэг)

4.6.5. Бусад шаардлагатай гэж үзсэн асуудлын талаар

4.7. Хянан шалгагч нь газар дээрх шалгалтаар даатгагчид учирч болзошгүй эрсдэлийн индексийг тодорхойлохдоо учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээ буюу даатгагчийн нийт эрсдэлийн үнэлгээ, удирдлага, хяналтын орчны үнэлгээ, санхүүгийн шинжилгээний үнэлгээний дундаж үзүүлэлтийг ашиглан энэхүү журмын 5 дугаар хавсралтад заасны дагуу тодорхойлно. Үүнд:

4.7.1. *Даатгагчийн нийт эрсдэлийн үнэлгээг хийхдээ дараах эрсдэлийн төрөл тус бүрээр даатгагчийн үйл ажиллагааг дүгнэж, эрсдэлийн үнэлгээнүүдийн дунджаар тодорхойлно. Эрсдэлийн төрөл тус бүрийн үнэлгээг энэхүү журмын 10 дугаар хавсралтад заасан “Даатгагчийн нийт эрсдэлийн үнэлгээ” хийх аргачлалаар боловсруулна.*

4.7.1.1. Үнэт цаас гаргагч, зээлдэгч, зуучлагч, даатгуулагч, давхар даатгагч болон баталгаа гаргагч зэрэг гуравдагч тал буюу харилцагчид төлбөрийн чадваргүй болох, гэрээний хариуцлагаа биелүүлэх боломжгүй болсны улмаас даатгагчид учирч болох эрсдэл буюу “Зээлийн эрсдэл”.

4.7.1.2. Зах зээлийн үнэ ба түвшинд өөрчлөлт орсноос үүдэн санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ болон ирээдүйн мөнгөн гүйлгээ хэлбэлзэх эрсдэл буюу “Ханш ба үнийн эрсдэл”. Үүнд хүүгийн түвшний эрсдэл, валютын ханшийн эрсдэл болон бусад үнийн эрсдэл зэрэг хамаарна.

4.7.1.3. Даатгалын бүтээгдэхүүний загвар ба үнэ тогтоолтын эрсдэл болон андеррайтинг ба хариуцлагын эрсдэл. Даатгалын бүтээгдэхүүний загвар ба үнэ тогтоолтын эрсдэл нь даатгалын үнэ тогтооход таамаглаж байсан хүлээлтээс даатгалын өртөг зардал, хариуцлага хэтрэх тохиолдол зэрэг даатгалын үйл ажиллагааны улмаас даатгагчид санхүүгийн хохирол үүсэхэд бий болдог эрсдэл буюу буюу “Даатгалын эрсдэл”. Андеррайтинг ба хариуцлагын эрсдэл нь даатгагчийн эрсдэлийг сонгох, хүлээж авах, бууруулах, авч үлдэх, шилжүүлэх болон даатгалын бүтээгдэхүүний удирдлагатай холбоотойгоор даатгагчид санхүүгийн хохирол учрах эрсдэл.

4.7.1.4. Бизнесийн үйл ажиллагааны зохион байгуулалт болон байгууллагын чиг үүргээс шалтгаалан бий болох эрсдэл буюу “Үйл ажиллагааны эрсдэл”. Үүнд дотоод хяналтын үйл ажиллагааны дутагдал, технологийн уналт, хувь хүн, ажилтнуудын алдаа болон үндэсний хэмжээний гамшиг сүйрэл хамаарна.

4.7.1.5. Даатгагч Даатгалын тухай хуулийн 2.1-т заасан даатгалын тухай хууль тогтоомжийг мөрдөөгүйн улмаас үүдэн гарах эрсдэл буюу “Хууль, зохицуулалтын хүрээний эрсдэл”.

4.7.1.6. Даатгагчийн бизнес төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө, шийдвэр гаргалт, нөөцийн хуваарилалтыг тохиромжтой байдлаар хэрэгжүүлээгүй болон бизнесийн орчинд гарсан өөрчлөлтөд дасан зохицох боломжгүй болсон тохиолдолд үүсэх эрсдэл буюу “Стратегийн эрсдэл”.

4.7.1.7. Компанийн нэгдэлд багтах компаниуд төлбөрийн чадваргүй болох, даатгагчтай хийгдсэн гүйлгээнүүд нь төлөгдөх боломжгүй болсноос үүдэн гарах эрсдэл буюу “Холбоотой талуудын эрсдэл”.

4.7.2. *Удирдлага, хяналтын орчны үнэлгээг хийхдээ төлөөлөн удирдах зөвлөл, компанийн удирдлага, үйл ажиллагааны удирдлага, эрсдэлийн удирдлага, хөндлөнгийн хяналтын үйл ажиллагаа тус бүрээр дүгнэж, үнэлгээнүүдийн дунджаар тодорхойлно. Удирдлага, хяналтын орчны үнэлгээг энэхүү журмын 11 дүгээр хавсралтад заасан “Даатгагчийн удирдлага, хяналтын орчны үнэлгээ” хийх аргачлалаар боловсруулна.*

4.7.3. *Санхүүгийн шинжилгээ хийхдээ санхүүгийн тогтвортой байдал, эрт анхааруулах шинжилгээний үзүүлэлтийг дүгнэж, үнэлгээнүүдийн дунджаар тодорхойлно.*

Санхүүгийн шинжилгээний үнэлгээг энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан “Санхүүгийн шинжилгээний үнэлгээ” хийх аргачлалаар боловсруулна. Санхүүгийн шинжилгээний үнэлгээний эрт анхааруулах шинжилгээг хийхдээ энэхүү журмын 15 дугаар хавсралтад заасан аргачлалыг ашиглана.

4.8. Хянан шалгагч нь энэхүү журмын 4.5-д заасны дагуу газар дээрх хяналт шалгалтаар даатгагчийн эрсдэлийн түвшинг тодорхойлсны дараа тодорхой эрсдэлийн түвшин өндөр хэсэг дээр нэмэлт материал шаардах болон нэмэлт шалгалтыг хийж гүйцэтгэж болно.

4.9. Шалгалтын ажлын хэсэг нь даатгагчийн үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсний дараа даатгагчийн эрсдэлийн түвшингээс хамаарч хянан шалгагчийн анхаарал түвшинг 1-50 хүртэл бол энэхүү журмын 3.5.1, 3.5.2, 3.5.3-т заасны дагуу холбогдох арга хэмжээг авна.

4.10. Эрсдэлийн түвшин 51-ээс дээш бол, анхаарал тавих түвшин “тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх” буюу хянан шалгагч даатгагчийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналыг Даатгалын тухай хуулийн дагуу Хорооны удирдлагад танилцуулна.

4.11. Шалгалтын ажлын хэсэг нь даатгагчийн үйл ажиллагаа, тухайн үеийн болон ирээдүйн санхүүгийн нөхцөл байдлыг харгалзан хянан шалгагчийн анхаарал тавих түвшинг бууруулж, эсхүл дээшлүүлж болно. Энэ тохиолдолд үндэслэл, тайлбарыг шалгалтын тайланд тусгаж, холбогдох баримтыг хавсаргасан байна.

#### **Тав. Газар дээрх шалгалтын тайлан бичих.**

5.1. Шалгалтын ажлын хэсэг газар дээрх шалгалтын тайланд дараах зүйлсийг тусган шалгалт дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор энэхүү журмын 17 дугаар хавсралтад заасан газар дээрх шалгалтын эрсдэлийн тайланг хавсарган компанийн удирдлагад танилцуулж, баталгаажуулна:

5.1.1. Шалгалтын удирдамжийн мэдээлэл;

5.1.2. Шалгалтын ажлын хэсгийн танилцуулга;

5.1.3. Шалгалтын зорилго, хэлбэр, хамрах хүрээ;

5.1.4. Шалгалтыг хэрэгжүүлсэн хэлбэр;

5.1.5. Даатгагчийн талаарх ерөнхий мэдээлэл, өмнөх шалгалтаас хойш орсон өөрчлөлт;

5.1.6. Даатгагчийн эрсдэлийн түвшинг эрсдэл тус бүрээр;

5.1.7. Хууль тогтоомж зөрчсөн талаарх мэдээлэл;

5.1.8. Зөрчлийг арилгуулахаар өгсөн арга хэмжээ;

5.1.9. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

5.2. Шалгалтын ажлын хэсэг газар дээрх шалгалтын тайланд тусгасан мэдээлэл, баримт материалуудыг баталгаажуулж тайланд хавсаргаж, даатгагчийн хувийн хэрэгт хавсарган хадгална.

5.3. Хянан шалгагч нь газар дээрх шалгалтын тайланг даатгагчийн удирдлагуудад танилцуулж, энэхүү журмын 3 дугаар хавсралтын дагуу тэмдэглэл хөтөлнө.

5.4. Даатгагчийн эрсдэлийн түвшин энэхүү журмын 4.9.3, 4.9.4, 4.9.5-д заасан түвшинд байвал илэрсэн зөрчил, дутагдлыг бууруулах болон эрсдэлийн түвшинг бууруулах талаар Шалгалтын ажлын хэсгийн ахлагч Улсын байцаагчийн албан шаардлагыг даатгагчид хүргүүлнэ.

#### **Зургаа. Хариуцлага**

6.1. Энэхүү журмыг зөрчсөний улмаас холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн тохиолдолд буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий албан тушаалтан хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Даатгагч тайлан, мэдээ, мэдээлэл ирүүлэхээс татгалзсан эсхүл ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл нь энэхүү журмын 2.3-т заасан шаардлагыг хангахааргүй бол хянан шалгагч дараах арга хэмжээг шат дараалан авна:

6.2.1. тайлан, мэдээ, мэдээллийг холбогдох хууль, тогтоомж болон албан бичигт заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэл нь энэхүү журамд заасан шаардлагыг хангахааргүй бол шаардлага хангасан тайлан, мэдээг нэн даруй ирүүлэхийг шаардаж, Даатгалын тухай хуулийн 65.1-т заасан мэдэгдлийг даатгагчийн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх;

6.2.2. энэхүү журмын 5.2.1-т заасан зөрчлийг давтан гаргасан бол улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх, шаардлагатай бол захиргааны хариуцлага ногдуулах;

6.2.3. даатгагч нь энэхүү журмын 5.2.1-т заасан зөрчлийг удаа дараа гаргасан, улсын байцаагчийн албан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг Хорооны удирдлагад танилцуулах.

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ....-ны өдрийн.... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 1 дүгээр хавсралт

### ДААТГАГЧИЙН ХУВИЙН ХЭРЭГ

Даатгагчийн нэр..... .... оны ... дүгээр сарын ...-ны өдөр

№	Тайлан, мэдээ, мэдээлэл	Бэлтгэсэн байдал	Бэлтгэсэн огноо	Тайлбар	Өөрчлөлт орсон огноо*
А	Б	1	2	3	4
А. Даатгагчийн ерөнхий мэдээлэл					
1	Тусгай зөвшөөрөл авсан огноо, шийдвэрийн дугаар				
2	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар				
3	Улсын бүртгэлийн дугаар				
4	Регистрийн дугаар				
5	Өмчлөлийн хэлбэр				
6	Албан ёсны хаяг, шуудан, утас, факсын дугаар				
7	Е-мэйл болон вэбсайт				
8	Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний тоо				
9	Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт**	Холбогдох журмын дагуу			
10	Даатгалын нөөц сангийн хөрөнгийн байршил**	Холбогдох журмын дагуу			
11	Балансын ерөнхий үзүүлэлт**	Энэхүү журмын 12 дугаар хавсралтын дагуу			
12	Орлого, үр дүнгийн тайлангийн ерөнхий үзүүлэлт**	Энэхүү журмын 13 дугаар хавсралтын дагуу			
13	Шуурхай шинжилгээний үзүүлэлт**	Энэхүү журмын 14 дүгээр хавсралтын дагуу			
14	Эрт анхааруулах системийн үзүүлэлт**	Энэхүү журмын 15 дугаар хавсралтын дагуу			
15	Тухайн жилд аудит хийлгэсэн компани, партнер, холбоо барих мэдээлэл				
16	Тухайн жилд хяналт хийлгэсэн актуарчийн нэр, холбогдох утас				
17	Газар дээрх шалгалтын талаар /шалгалтын ажлын хэсгийн				

	бүрэлдэхүүн, хэлбэр, хийсэн хугацаа/				
18	Даатгагчийн эрсдэлийн үнэлгээ				
19	Даатгагчийн эрсдэлийн түвшин				
20	Хянан шалгагчийн анхаарал тавих түвшин				
<b>Б. Эрсдэлийн удирдлага</b>					
21	Эрсдэлийн удирдлага, түүний хяналт болон удирдлагын процесс**				
22	Эрсдэлийн удирдлагын бодлого**				
23	Эрсдэлийн удирдлагын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааны талаар баримт материал**				
24	Эрсдэлийн удирдлагын үйл явц нь хууль болон зохицуулалтын дагуу байдаг эсэх талаар**				
<b>В. Үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, мэдээ</b>					
25	Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан, нэмэлт тайлангууд**				
26	Даатгагчтай холбоотой гадны эх сурвалжаас олж авсан мэдээллүүд				
27	Даатгагчийн бодлого, журам, дүрэм, аргачлал болон бусад баримт, бичгүүд** Үүнд: Бизнес төлөвлөгөө болон санхүүгийн төлөвлөгөөг зайлшгүй авах				
28	Дотоод хяналтын үйл ажиллагааны журам болон тайлангууд**				
29	Хөндлөнгийн аудитын даатгагчид илгээсэн удирдлагын захидал болон бусад холбогдох баримт материалууд**				
30	Хөндлөнгийн актуарчийн тайлан, холбогдох мэдээллүүд**				
31	Бусад холбогдох материал**				
<b>Г. Даатгагчийн бүтэц, зохион байгуулалт</b>					
32	Даатгагч групп компанид хамаардаг бол групп компанийн бүтэц, зохион байгуулалт, бүтцэд багтаж буй нэгдлийн гишүүн тус бүрийн үйл ажиллагааны чиглэл**				
33	Даатгагчийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт болон				

	нэгж тус бүрийн ажил үүргийн хуваарь, нэгж тус бүрийг хариуцаж буй ажилтны мэдээллүүд**				
34	Даатгагчийн салбар, төлөөлөгчийн газруудын байршил, үйл ажиллагааны чиглэл, хариуцаж буй ажилтан зэрэг холбогдох мэдээлэл**				
	Даатгагчийн стратеги болон бизнес төлөвлөгөө, бусад төлөвлөгөөнүүд**				
35	Төлөөлөн удирдах зөвлөл болон Аудитын хорооны хурлын тэмдэглэлүүд**				
36	Бусад холбогдох мэдээллүүд**				
Д. Мэдээллийн технологи					
37	Даатгагчийн мэдээллийн системийн талаарх мэдээлэл				
38	Мэдээллийн технологийн стандарт болон үйл явц, Сүлжээний мэргэжилтнүүдийн нэрс, холбоо барих утас болон мэдээллийн аюулгүй байдал**				
		хангалттай	1					

6.8	Компанийн засаглалын үнлэсний эрсдэлийн төвшин хуудаст компанийн засаглалын талаарх мэдээллийг ил тод гаргадаг уу?	хангалттай	1			
	Ил тод байдлын нийт үнэлгээ	хангалтгүй	3			
УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ						
УДИРДЛАГА, ХЯНАЛТЫН ОРЧНЫ ТҮВШИН**						
						0.000

\*\* Удирдлага, хяналтын орчны түвшинг орчны үнэлгээтэй уялдуулан дараах байдлаар тодорхойлно:

Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн түвшин
0-1 хүртэл	Хүчтэй
1-1.75 хүртэл	Эрүүл
1.75-2.5 хүртэл	Хангалттай
2.5-3.5 хүртэл	Эмзэг
3.5-аас дээш	Сул

Боловсруулсан:

Ажлын хэсгийн гишүүн: ..... /

Огноо: .....

Хянасан:

Ажлын хэсгийн ахлагч.....

Огноо: .....

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 12 дугаар хавсралт

ДААТГАГЧИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН  
ҮЗҮҮЛЭЛТИЙН ШИНЖИЛГЭЭ

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Харьцуулсан шинжилгээ			
		Тайлант он	%	Өмнөх оны мөн үе	%
1	Нийт хөрөнгийн дүн				
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө				
1.2	Даатгалын авлага				
1.3	Бусад авлага				
1.4	Бараа материал				
1.5	Урьдчилж төлсөн тооцоо				
1.6	Хөрөнгө оруулалтын дүн				
1.7	Даатгалын хөрөнгийн дүн				
1.8	Биет бус хөрөнгө				
1.9	Үндсэн хөрөнгө /цэвэр/				
2	Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн				
2.1	Даатгалын өглөг				
2.2	Бусад санхүүгийн бус өр төлбөр				
2.3	Нөөц сан				
2.4	Нийт өр төлбөрийн дүн				
2.5	Эзэмшигчдийн өмч				
2.6	Хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт				
2.7	Эздийн өмчийн бусад хэсэг				
2.8	Хуримтлагдсан ашиг, алдагдал				
2.9	Эздийн өмчийн дүн				

Боловсруулсан:

Хянан шалгагч: ..... /

Огноо: .....

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
 2018 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн... дүгээр тушаалаар  
 баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
 суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 13 дугаар хавсралт

### ДААТГАГЧИЙН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

#### А. Орлогын бүтэц, бүрэлдэхүүний талаар:

Үзүүлэлт	Тайлант он, улирал	%	Өмнөх оны тайлант үе	%
Даатгалын нийт хураамжийн орлого				
Давхар даатгалын хураамж				
Буцаасан даатгалын хураамж				
Даатгалын цэвэр хураамжийн орлого				

#### Б. Зардлын бүтэц бүрэлдэхүүний талаар:

Үйл ажиллагааны зардлыг 100% гэж тооцон бусад үзүүлэлтүүдийн хувийн жинг тодорхойлно.

Үзүүлэлт	Тайлант он, улирал	%	Өмнөх оны тайлант үе	%
Үйл ажиллагааны зардал				
Ерөнхий ба удирдлагын зардал				
Даатгалын гэрээний зардал				
Борлуулалт маркетингийн зардал				
Санхүүгийн зардал				
Бусад зардал				

Боловсруулсан:

Хянан шалгагч: ..... /

Огноо: .....

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 14 дүгээр хавсралт

### ДААТГАГЧИЙН ШУУРХАЙ ШИНЖИЛГЭЭ

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

	Шинжилгээний зорилго	Үзүүлэлт	Тооцох журам	Өмнөх оны тайлант үе	Тайлант оны улирал
1	Хөрөнгийн байдлын үнэлгээ	1. Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 2. Хөрөнгийн элэгдэл  3. Нийт хөрөнгийн өсөлт	1. Үндсэн хөрөнгө/Нийт хөрөнгө*100%  2. Хур.элэгдэл/ Биет ба биет бус хөрөнгийн анхны өртөг*100% 3. Оны эхний нийт хөрөнгө/оны эцсийн нийт хөрөнгө*100%		
2	Санхүүгийн байдлын үнэлгээ	1.Өөрийн хөрөнгийн хувийн жин 2.Эргэлтийн харьцаа  3.УХӨТ-ийн нийт эх үүсвэр эзлэх %-ийн жин 4. Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин	1.Өөрийн хөрөнгө/Нийт эх үүсвэр *100% 2.Эргэлтийн хөрөнгө/БХӨТ 3.УХӨТ/Нийт эх үүсвэр*100% 4. Нөөц сан/Нийт эх үүсвэр		
3	Ашигт ажиллагааны үнэлгээ	1.Цэвэр ашгийн өөрчлөлт 2.Нийт ашгийн түвшин  3.Үйл ажиллагааны ашгийн түвшин  4.Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа 5. Даатгагчид үлдэх хураамжийн хувь  6. Даатгалын цэвэр ашгийн хувь 7. Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа	1.ЦА абсолют хэлбэлзэл 2.Нийт ашиг/Орлогод тооцсон хураамж 100% 3.Үйл ажиллагааны ашиг/Даатгалын хураамжийн орлого*100% 4. Цэвэр ашиг/Өөрийн хөрөнгө 5. Даатгалын цэвэр орлого/ Нийт даатгалын орлого 6. Цэвэр ашиг/Орлогод тооцсон хураамж 7. Цэвэр ашиг/Нийт хөрөнгө		

4	<p>Даатгалын үйл ажиллагааны шинжилгээ</p>	<p>Даатгалын үнэлгээний хүртээмж, хураамж үнэ тогтоолт хэрхэн хийгдсэнийг тогтооход чиглэгдэнэ.</p> <p>1.Хохирлын харьцаа</p> <p>2.Зардлын харьцаа</p> <p>3.Хосолсон харьцаа</p> <p>4.Үйл ажиллагааны харьцаа</p> <p>Даатгалын төвлөрлийн үзүүлэлтийг даатгалын эрсдэлийн газар зүйн байрлал болон бусад хүчин зүйлээр нь авч үзнэ.</p> <p>6-8 Өөрийн хөрөнгийн хүрэлцээ</p>	<p>1. Нийт нэхэмжлэл /орлогод тооцсон хураамж</p> <p>2. Үйл ажиллагааны зардал/ орлогод тооцсон хураамж</p> <p>3.Хохирол нөхөлтийн харьцаа+ зардлын харьцаа</p> <p>4.Хөрөнгө оруулалтын орлогоор тохируулга хийгдсэн холимог харьцаа буюу холимог харьцаан дах орлого тооцсон хураамж дээр хөрөнгө оруулалтын орлогыг нэмнэ.</p> <p>Хэрэв үйл ажиллагааны харьцаа 100 хувиас хэтрэх, хураамжийн орлого, хохирол болон зардлын түвшин тараан байршуулсан хөрөнгөөс хэтэрсэн тохиолдолд хөрөнгө оруулсан хөрөнгийн өгөөжид сөргөөр нөлөөлнө.</p> <p>6. Дүрмийн сан/хураамжийн орлого</p> <p>7. Дүрмийн сан/ нөөц сан</p> <p>8. Дүрмийн сан/нөхөн төлбөр</p>		
5	<p>Мэдрэмжийн шинжилгээ</p>	<p>Мэдрэмтгий байдал /Хэрэв шаардлагатай бол тооцож болно./</p>	<p>1. Нөхөн төлбөрийн 1 хувийн өөрчлөлтөөс эзэмшигчийн өмчид үзүүлэх нөлөөлөл</p> <p>2.Инфляцийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн даатгалын өр төлбөрт үзүүлэх нөлөөлөл,</p>		



			3.Хүүгийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн хөрөнгөд үзүүлэх нөлөөллүүд, хөнгөлттэй үед 4. Хүүгийн түвшний 10 хувийн өөрчлөлтийн даатгалын өр төлбөрт үзүүлэх нөлөөллүүдийг тооцно.	
6	Өсөлтийн үнэлгээ	1.ЭХ- ийн эргэц  2.Авлагын эргэц  3.Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа	1.Даатгалын хураамжийн орлого /Оны эхний ба эцсийн эргэлтийн хөрөнгийн дундаж 2.Даатгалын хураамжийн орлого/Оны эхний ба эцсийн авлагын дундаж 3.Цэвэр ашиг/Өөрийн хөрөнгө /Зөвхөн жилийн эцэст тооцно/	

Боловсруулсан:

Хянан шалгагч: ..... /

Огноо: .....

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ....-ны өдрийн.... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 15 дугаар хавсралт

## ЭРТ АНХААРУУЛАХ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

### 1. Жилийн нийт ба цэвэр хураамжийн өөрчлөлт

Энэ нь даатгалын эрсдэлийн нэг томоохон үзүүлэлт юм. Хураамжийн огцом өсөлт, бууралт нь байгууллагын стратеги бусад хүчин зүйлүүдийг өөрчлөхөд хүргэж болно. Тухайлбал огцом өсөлт нь мэдээлэл, програм, нягтлан бодох бүртгэл, бусад дотоод хяналт, үйл ажиллагааны системд огцом нөлөө үзүүлэх эрсдэлийг авчирдаг. Өсөлт нь ихэвчлэн шинэ зах зээлд нэвтрэх, зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх оролдлогыг харуулдаг. Давхар даатгалын нэмэлт хэлцлүүд мөн орлогын өсөлтийг авчрах бөгөөд ингэснээр эрсдэлийг нэмэгдүүлнэ. Зарим тохиолдолд үнээ өрсөлдөгчдөөсөө хэт буулгах тохиолдол байдаг. Ингэснээр даатгагчид доогуур үнэлгээний улмаас бага хэмжээний хураамжид их хэмжээний эрсдэл үүрэх, үүнээс үүдэн илүү их хөрвөх чадвартай хөрөнгө шаардах нөхцөлийг бүрдүүлдэг. Эсрэгээр хураамжийн бууралт нь зах зээлд эзлэх хувийг бууруулдаг. байгууллагын цалин, түрээс зэрэг тогтмол зардлын улмаас зардлын харьцаа нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл тогтмол зардал нь компанийн бууралттай орлогын хувьд илүү өндөр хувийг эзлэн улмаар ашгийг бууруулахад нөлөөлнө.

Харьцаа:

/ Жилийн нийт ба цэвэр хураамжийн өөрчлөлт =(Тайлант үе-өмнөх үе) / Өмнөх үе

*Боломжит түвшин:*

33% >= Жилийн нийт ба цэвэр хураамжийн өөрчлөлт >=-33%

### 2. Даатгалын эрсдэлийн харьцаа:

Цаг агаар, газар хөдлөлт, гал түймэр болон бусад гамшгийн хохирол тодорхойгүй байдгийн нэгэн адил ердийн даатгал нь маш их хэлбэлзэлтэй байдаг. Хосолсон харьцаа 80-120% гэж үзье. Хэрэв цэвэр хураамж 100 бол ашиг эсхүл алдагдлын дээд хэмжээ 20 байна. Хувьцаа 50 гэвэл харьцаа 100-г 50-д хуваагаад 2 гарна. Хосолсон харьцаа 80 гэвэл даатгалын ашиг 20, харин 120 гэвэл даатгалын алдагдал -20 байна. 80 үед хувьцааны өгөөж 40% бол 120 үед хувьцааны өгөөж -40% болно. Энд цэвэр эрсдэлийн харьцаа 2 үед хувьцааны өгөөж -40-өөс 40 хүртэл хэлбэлзэж байна. Цэвэр эрсдэлийн харьцааг одоо 5 гэе. Хувьцаа адил 50 гэвэл хураамжийн хэмжээ 250 болно /хувьцаа\*эрсдэлийн харьцаа=50\*5/. Одоо хосолсон харьцаа 80 бол даатгалын ашиг 50, хувьцааны өгөөж 100 буюу 50-ийн ашиг дээр 50-ийн хувьцааг нэмсэнтэй тэнцүү болно. Харин 120 үед 50-ийн алдагдалтай, хувьцааны өгөөж -100 буюу 50-ийн алдагдлыг хувьцаанд хуваасантай тэнцэнэ. Үүнээс үзэхэд эрсдэлийн харьцаа өсөхөд даатгалын алдагдлын магадлалт хэмжээ мөн адил хувиар өсөж, харин хувьцаа хэвээр үлдэх ба үүнд үзүүлэх боломжит нөлөөлөл мөн дээрх хувиар өсөхөөр байна. Даатгагчийн хувьд эрсдэлийн харьцааг хувьцааны өгөөжийг өндөр байлгах зорилгоор аль болох өндөр байлгахыг хүсдэг. Харин зохицуулагч нь эрсдэлийн харьцаа өндөр, даатгалын үр дүн хасах байвал тухайн байгууллагын хувьцаанд сөргөөр нөлөөлнө хэмээн болгоомжтой ханддаг. Өмнөх практикаас энэ харьцаа 3-аас дээшгүй байх боломжтойг харуулдаг. Нийт харьцааны хувьд давхар даатгал нэмэгдэн орж ирэх бөгөөд давхар даатгалын эрсдэлийг багтаасан байна. Иймээс мөн хязгаарлалт байх шаардлагатай.

1/ Цэвэр эрсдэлийн харьцаа=Цэвэр хураамж / Эзэмшигчийн өмч

*Боломжит түвшин:*

Цэвэр эрсдэлийн харьцаа  $\leq 3$

2/ Нийт эрсдэлийн харьцаа = Нийт хураамж / Эзэмшигчийн өмч

*Боломжит түвшин:*

Нийт эрсдэлийн харьцаа  $\leq 7$

3. Нэхэмжлэлийн харьцаа:

Дэлхийн банк хөгжингүй орны хувьд 50%-80% гэж зөвлөдөг.

Харьцаа:

Төлсөн нэхэмжлэл / Орлогод тооцсон цэвэр хураамж

*Боломжит түвшин:*

75%  $\geq$  Нэхэмжлэлийн харьцаа  $\geq 30\%$

4. Зардлын харьцаа:

Дэлхийн банк хөгжингүй орны хувьд 25%-50% гэж зөвлөдөг.

Харьцаа:

Зардал / Орлогод тооцсон цэвэр хураамж

*Боломжит түвшин:*

60%  $\geq$  Зардлын харьцаа  $\geq 25\%$

5. Хосолсон харьцаа:

Хосолсон харьцаа 100%-иас их нөхцөлд компани хөрөнгө оруулалтын ашигтай ажиллах шаардлагатай. Хөрөнгө оруулалтын өндөр орлоготой үед компани зах зээлд эзлэх хувиа нэмэгдүүлэх зорилгоор хураамжаа бууруулан алдагдал хүлээж тэр алдагдлаа хөрөнгө оруулалтаар нөхөхийг эрмэлздэг. Энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын орлого буурвал компани санхүүгийн эрсдэлд орох магадлалтай.

Харьцаа:

Төлсөн цэвэр нэхэмжлэл ба зардал / Орлогод тооцсон цэвэр хураамж

*Боломжит түвшин:*

105%  $\geq$  Хосолсон харьцаа  $\geq 85\%$

6. Өөрт үлдээх эрсдэлийн харьцаа:

Энэ нь компани хэдий хэмжээний бизнес өөртөө үлдээх, хэдийг давхар даатгавал зохихыг тодорхойлно.

Харьцаа:

Цэвэр хураамж / Нийт хураамж

*Боломжит түвшин:*

80%  $\geq$  Өөрт үлдээх эрсдэлийн харьцаа  $\geq 40\%$

7. Эзэмшигчийн өмчийн өөрчлөлтийн харьцаа:

Энэ харьцаа нь компанийн хувьцааны жил жилийн өөрчлөлт үйл ажиллагаанд нь хэрхэн нөлөөлж байгааг харуулна. Компани төлбөрийн чадваргүй болоход хувьцаа хамгийн сүүлийн хамгаалалт нь болдог ба үүнд орох өөрчлөлт нь компанийн санхүүгийн эрсдэлийн чухал үзүүлэлт болдог.

Харьцаа:

(тайлант үеийн Эзэмшигчийн өмч ба нэмж оруулсан хөрөнгийн ялгавар-өмнөх үеийн Эзэмшигчийн өмч ба нэмж оруулсан хөрөнгийн ялгавар) / Өмнөх үеийн Эзэмшигчийн өмч ба нэмж оруулсан хөрөнгийн ялгавар

*Боломжит түвшин:*

-10%  $\geq$  Эзэмшигчийн өмчийн өөрчлөлтийн харьцаа  $\geq$  25%

8. Авлагын сорил:

Их хэмжээний өр төлбөртэй даатгалын мэргэжлийн оролцогч дампуурвал компанид томоохон эрсдэл үүсгэнэ. Авлага төлөгдөхгүй бол компанийн хувьцаанд нөлөөлнө.

Харьцаа:

Хураамжийн авлага / Эзэмшигчийн өмч

*Боломжит түвшин:*

20%  $\geq$  Авлагын сорил

9. Хувьцаанд эзлэх холбогдох этгээдийн өр:

Тухайн группэд санхүүгийн хүндрэл учирвал мөнгө төлөгдөхгүй байх эрсдэлтэй.

Харьцаа:

Холбогдох этгээдээс төлөх өр / Эзэмшигчийн өмч

*Боломжит түвшин:*

10%  $\geq$  Хувьцаанд эзлэх холбогдох этгээдийн өр

10. Өр төлбөрт эзлэх Эзэмшигчийн өмчийн эзлэх хувь хэмжээ:

Энэ нь чухал харьцаа бөгөөд даатгагч даатгуулагчийн өмнө хүлээх үүргийн биелэлтийг харуулах үзүүлэлт юм. Энэ харьцаа бага бол даатгагчид учирч болох гэнэтийн урьдчилж хараагүй эрсдэл /даатгалын алдагдал, хөрөнгө оруулалтын алдагдлыг тооцохгүйгээр гамшгийн эрсдэл, давхар даатгагчийн дампуурал зэрэг/-д санхүүгийн чадавх хүрэлцэхгүй болно. Компанийн өр төлбөрийн тооцоололд тодорхой тохируулга хийх шаардлагатай ба жишээ нь хөрөнгийн илүү үнэлгээ, өр төлбөр нөөцийн доогуур үнэлгээ зэргийг дурдаж болно.

Харьцаа:

Эзэмшигчийн өмч / (өр төлбөр ба зохицуулагчаас шаардсан нөөц)

*Боломжит түвшин:*

Өр төлбөрт эзлэх Эзэмшигчийн өмчийн хэмжээ  $\geq$  25%

11. Хөрөнгө оруулалтын өгөөж:

6 сарын хугацаатай ЗГ өрийн бичгийн дундаж хувьтай тэнцүү байна. Өндөр өгөөж өндөр эрсдэлийг дагуулдаг.

Харьцаа:

Хөрөнгө оруулалтын цэвэр орлого / оны эхэн ба эцсийн дундаж хөрөнгө оруулалт

*Боломжит түвшин:*

Хөрөнгө оруулалтын өгөөж > 3Г өрийн бичгийн 6 сарын дундаж хүү

12. Хөрвөх харьцаа:

Даатгалын компанийн тогтвортой үйл ажиллагаа нь компанийн хөрвөх эрсдэлийн удирдлага сайн байгааг харуулна. Олон даатгагч энэ харьцаа алдагдсаны улмаас дампууралд хүрч байсан.

Харьцаа:

(Бэлэн мөнгө+3Г бонд+Хадгаламж) / Нийт өр

*Боломжит түвшин:*

95% >= Хөрвөх харьцаа

13. Аюулгүй байдлын харьцаа:

Нөөцөд нөхөн төлбөрийн, хохирлын үнэлгээний зардлын, хуулийн зардлын болон УБНХН орно. Хэрэв төлөөгүй нэхэмжлэлийн дүн эзэмшигчийн өмчөөс 1.5 дахин өндөр бол нэхэмжлэлийн хариуцлагын 10 хувийн дутуу тооцоо нь эзэмшигчийн өмчийн 15%-тай тэнцүү байна. Харьцаа 5:1 бол нэхэмжлэлийн хариуцлагын 10% дутуу тооцоо нь хувьцааны 50% болно гэсэн үг.

Харьцаа:

Нэхэмжлэлийн цэвэр нөөц (төлбөрийн, хохирлын үнэлгээний зардлын, хуулийн зардлын болон УБНХН) / Эзэмшигчийн өмч

*Боломжит түвшин:*

2.5 >= Аюулгүй байдлын харьцаа

14. Эзэмшигчийн өмчийн өгөөж:

Эзэмшигчийн өмчийн өгөөж нь аливаа компанийн санхүүгийн гүйцэтгэлийг хэмжих нэг чухал хэмжүүр юм. Хасах эсхүл бага үзүүлэлт нь компанийн санхүүд асуудал үүссэнийг харуулна. Энэ үзүүлэлт нь хөрөнгө оруулагчийн шийдвэрт нөлөөлнө.

Харьцаа:

Цэвэр орлого / ( Эзэмшигчийн өмчийн оны эхэн ба эцсийн дүнгийн дундаж хувь)

*Боломжит түвшин:*

Өмнөх тайлант үеийн бүх компанийн дундаж > Эзэмшигчийн өмчийн өгөөж

15. Нэхэмжлэлийн нөөцийн хүрэлцээт байдлын харьцаа:

Тухайн жилд байгуулсан нөөц тухайн жилийн нэхэмжлэлд хангалттай эсэхийг харуулдаг хэмжүүр юм. Нэхэмжлэлийг хэт багаар тооцсон бол ашиг нь өндөр гарна. Энэ тохиолдолд тайланд залруулга хийгдэнэ.

Харьцаа:

Өмнөх оны шийдвэрлээгүй хохирлын илүүдэл, дутагдал / Эзэмшигчийн өмч

*Боломжит түвшин:*

-10%  $\geq$  Нэхэмжлэлийн нөөцийн хүрэлцээт байдлын харьцаа

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 16 дугаар хавсралт

"... ДААТГАЛ" ХХК-ИЙН ЗАЙНЫ ХЯНАЛТЫН ДҮГНЭЛТ

".....даатгал" ХХК-ийн ..... оны ... дүгээр улирлын санхүү, даатгалын үйл ажиллагаанд зайны хяналтыг хийж гүйцэтгэлээ.

Тус компаниас ирүүлсэн санхүүгийн тайлан болон холбогдох материалаас үзэхэд "... даатгал" ХХК-ийн эрсдэлийн түвшин дараах байдалтай байна:

1. Учирч болох эрсдэлийн түвшин .... буюу эрсдэлийн индекс ... байна. Үүнд:

№	Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн түвшин
1	Чанарын үзүүлэлтийн үнэлгээ		
	Даатгагчийн ерөнхий мэдээлэл		
	Эрсдэлийн удирдлага		
	Андеррайтингийн эрсдэл		
	Зах зээл, хөрвөх чадвар болон зээлийн эрсдэл		
	Үйл ажиллагааны эрсдэл		
	Давхар даатгал		
	Группийн эрсдэл		
	Хэрэглэгч, зах зээл болон бүтээгдэхүүн		
	Чанарын үзүүлэлтийн эрсдэлийн дундаж үнэлгээ		
2	Санхүүгийн үзүүлэлтийн үнэлгээ		
	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ		
	Эрт анхааруулах шинжилгээ		
	Санхүүгийн үзүүлэлтийн үнэлгээний дундаж үнэлгээ		
3	Учирч болох эрсдэлийн үнэлгээ		

Хорооны 2016 оны 105 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын байгууллагын төлбөрийн чадварыг тооцох журам”-д зааснаар компанийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг тооцоход төлбөрийн чадварын зохистой харьцаа ..... хувь буюу ..... (төлбөрийн чадваргүй болж болзошгүй, төлбөрийн чадвартайд тооцогдож байгаа эсэх).

2. Зах зээлийн нөлөөллийн түвшин ... буюу нөлөөллийн индекс... байна. Үүнд:

№	Үзүүлэлт	Нөлөөллийн үнэлгээ	Нөлөөллийн түвшин
1	Даатгуулагчдын тоо		
2	Даатгалын компанийн салбарын тоо		
3	Даатгалын хураамжийн орлого		
4	Даатгалын бүтээгдэхүүний багцын эрсдэл		
5	Зах зээлийн нөлөөллийн индекс		

3. "... даатгал" ХХК-ийн эрсдэлийн түвшин ... буюу хянан шалгагчийн анхаарал тавих түвшин ... байна.

4\*. Хянан шалгагчийн анхаарал тавих түвшин " ..." гарсан хэдий ч даатгагчийн эрсдэлийн нийт үнэлгээ нь дараах эрсдэлүүдийн хувьд 2.5 ба түүнээс дээш гарсан тул хянан шалгагчийн анхаарал тавих түвшинг "газар дээрх хяналт шалгалт" түвшин рүү шилжүүлэх саналтай байна. Үүнд:

№	Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн түвшин
1			
2			

5\*. Хянан шалгагчийн анхаарал тавих түвшин "..." гарсан хэдий ч даатгагчийн чанарын үзүүлэлтийн үнэлгээ дараах үзүүлэлтүүдийн хувьд 2.5 ба түүнээс дээш гарсан тул хянан шалгагчийн анхаарал тавих түвшинг "газар дээрх хяналт шалгалт түвшин рүү шилжүүлэх саналтай байна. Үүнд:

№	Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн түвшин
1			
2			

6\*. Хянан шалгагчийн анхаарал тавих түвшин "..." гарсан хэдий ч даатгагчийн санхүүгийн шинжилгээний эрсдэлийн нийт үнэлгээ нь дараах үзүүлэлтүүдийн хувьд 2.5 ба түүнээс дээш гарсан тул хянан шалгагчийн анхаарал тавих түвшинг "газар дээрх хяналт шалгалт түвшин рүү шилжүүлэх саналтай байна. Үүнд:

№	Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн түвшин
1			
2			

\* Журмын 3.6-д заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэхүү хэсгийг дүгнэлтэд оруулж бичнэ.

Хянан шалгагчийн	
Нэр	
Гарын үсэг	
Огноо	



Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгалын компанийн үйл ажиллагаанд эрсдэлд  
суурилсан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх журам”-ын 17 дугаар хавсралт

"... ДААТГАЛ" ХХК-ИЙН ГАЗАР ДЭЭРХ ШАЛГАЛТЫН  
ЭРСДЭЛИЙН ТАЙЛАН

Даатгагчийн нэр.....

20...оны ... сарын ...-ны өдөр

1. Учирч болох эрсдэлийн түвшин .... буюу эрсдэлийн индекс ... байна. Үүнд:

№	Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн үнэлгээ	Эрсдэлийн түвшин
1	Нийт эрсдэлийн түвшин		
	Зээлийн эрсдэлийн нийт үнэлгээ		
	Ханш ба үнийн эрсдэлийн нийт үнэлгээ		
	Даатгалын эрсдэлийн нийт үнэлгээ		
	Үйл ажиллагааны эрсдэлийн нийт үнэлгээ		
	Хууль, зохицуулалтын хүрээний эрсдэлийн нийт үнэлгээ		
	Стратегийн эрсдэлийн нийт үнэлгээ		
	Холбоотой талуудын эрсдэлийн нийт үнэлгээ		
2	Удирдлага, хяналтын орчин		
	Төлөөлөн удирдах зөвлөл		
	Компанийн удирдлага		
	Үйл ажиллагааны удирдлага		
	Эрсдэлийн удирдлага		
	Дотоод болон хөндлөнгийн хяналт		
	Ил тод байдал		
3	Санхүүгийн шинжилгээ		
	Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ		
	Эрт анхааруулах шинжилгээ		
4	Учирч болох эрсдэлийн үнэлгээ		

2. Зах зээлийн нөлөөллийн түвшин ... буюу нөлөөллийн индекс... байна. Үүнд:

№	Үзүүлэлт	Нөлөөллийн үнэлгээ	Нөлөөллийн түвшин
1	Даатгуулагчдын тоо		
2	Даатгалын компанийн салбарын тоо		
3	Даатгалын хураамжийн орлого		
4	Даатгалын бүтээгдэхүүний багцын эрсдэл		
5	Зах зээлийн нөлөөллийн индекс		

3. "... даатгал" ХХК-ийн эрсдэлийн түвшин ... буюу хянан шалгагчийн анхаарал тавих түвшин ... байна.

4\*. Хянан шалгагчийн анхаарал тавих түвшин " ..." гарсан хэдий ч дараах шалтгааны улмаас анхаарал тавих түвшинг ..... рүү шилжүүлэх саналтай байна. Үүнд:

№	Эрсдэлийн төрөл	Эрсдэлийн түвшин	Шилжүүлэх саналтай эрсдэлийн түвшин	Шилжүүлэх шалтгаан
1				
2				

Боловсруулсан:


Ажлын хэсгийн гишүүн: ..... /

Огноо: .....

Хянасан:

Ажлын хэсгийн ахлагч.....

Огноо: .....



## **ДААТГАГЧ ӨӨРИЙН ЭРСДЭЛ БОЛОН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРАА ҮНЭЛЭХ ЗААВАР**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэ зааврын зорилго нь даатгагчийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх арга, аргачлалын загварыг тогтоосноор учирч болзошгүй эрсдэлээ тодорхойлох, хэмжих, зохистойгоор удирдах, хянах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Даатгагч үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх эрсдэлийг удирдах стратегитай байна. Даатгагч нь эхний ээлжид өөрийн бизнесийн зорилт болон байгаа боломжит нөөцөө харгалзан дааж чадахуйц эрсдэл буюу эрсдэл даах/хүлцэх чадвараа тодорхойлох шаардлагатай. Эрсдэлийн удирдлагын стратегиа боловсруулах явцад дараах асуудлыг судалсан байна:

1.2.1. эдийн засаг, зах зээлийн төсөөлөл, тэдгээрээс даатгагчийн үйл ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөөлөл;

1.2.2. зах зээлийн тодорхой сегмент дэх бизнесийн зорилгодоо хүрэх болон тухайн эрсдэлүүдийг таних, хэмжих, хянах боловсон хүчний нөөцөө тодорхойлох

1.2.3. эрхэлж буй даатгалын төрөл, хэлбэр, төвлөрлийн байдал.

1.3. Даатгагч нь тодорхой хугацааны давтамжтайгаар өөрийн санхүүгийн байдал болон зах зээлийн хөгжлийн нөхцөл байдлыг харгалзан эрсдэлийн удирдлагын стратегиа дахин эргэж судалж байх шаардлагатай. Даатгагчийн үйл ажиллагаа, бизнесийн стратегид томоохон өөрчлөлт гарсан бол эрсдэлийн удирдлагын стратегиа мөн өөрчлөх эсэх талаар судалж үзэх нь зүйтэй. Стратегид өөрчлөлт оруулахдаа холбогдох ажилтнуудыг оролцуулан хэлэлцэнэ. Батлагдсан стратегиас зөрсөн гэнэтийн өөрчлөлтийн талаар хяналт баталгаажилтын үйл ажиллагаа заавал байх шаардлагатай.

### **Хоёр. Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ хийх аргачлал, түүнд тавигдах шаардлага**

2.1. Даатгагч энэ зааврын дагуу өөрийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, эрсдэлийн удирдлагын стратегид тохирохуйц бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, цар хүрээ, харилцан хамааралтай шинж чанарыг харгалзан хамгийн тохиромжтой, хангалттай аргачлал, техникийг багтаасан эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх аргачлал /цаашид “үнэлгээний аргачлал”/- тай байна.

2.2. Даатгагч энэ зааврын 2.1-т заасан үнэлгээний аргачлал, түүнд орох өөрчлөлтийг төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах ба баталснаас хойш 14 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

2.3. Даатгагчийн үнэлгээний аргачлалд дараах шаардлага тавигдана:

2.3.1. зээлийн эрсдэл, ханш ба үнийн эрсдэл, даатгалын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, хууль ба зохицуулалтын хүрээний эрсдэл, стратегийн эрсдэл, холбоотой талуудын эрсдэл бүрийг тооцоолж, хэрхэн удирдах бодлого, стратегийг байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлоготой уялдуулан боловсруулсан байна.

2.3.2. Даатгагч өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, хүрээ, нарийн төвөгтэй байдал зэргээс хамааруулан энэ зааврын 2.1-т зааснаас өөр эрсдэлийг хамааруулж болно.

2.4. Даатгагч энэ зааврын 2.2-т заасан үнэлгээний аргачлалд дараах зүйлсийг заавал тусгана:

2.4.1. Эрсдэлийн соёл ба засаглал: Засаглалын бүтэц нь эрсдэлд суурилсан шийдвэр гаргалтын ил тод, хариуцлагатай байдлыг дэмжих эрсдэлийн соёл болон үйл ажиллагаан дахь үүрэг, хариуцлага, тайлагналыг тодорхойлж, тусгасан байх шаардлагатай. Мэдээллийн чанарын асуудлыг энэ хэсэгт тусгана.

2.4.2. Эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлэх: Энэ процесс нь байгууллагын хамгийн чухал процесс бөгөөд үйл ажиллагаа бүрийн хариуцагч нь ойлгомжтой тодорхойлогдсон, эрсдэлийн удирдлагын үүрэг, функц нь байгууллагын бүхий л түвшинд тохиромжтой тодорхойлогдсон эсэхийг баталгаажуулсан байх.

2.4.3. Эрсдэл хүлээж авах сонирхол, эрсдэл үүрэх болон түүний хязгаар: Даатгагчийн хувьд эрсдэл хүлээн авах сонирхлын шийдвэр, холбоотой эрсдэлийн үүрэх хязгаар зэрэг нь эрсдэлийн удирдлагын хамгийн чухал үзүүлэлт юм. ТУЗ нь эрсдэл хүлээж авах сонирхлын шийдвэр нь эрсдэлийн стратегитай нийцэж буй эсэхийг хянаж үзэх шаардлагатай.

2.4.4. Эрсдэлийн удирдлага ба хяналт: Эрсдэлийг удирдах нь байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж буй хэлбэр бөгөөд байгууллагын дотор бүхий л түвшинд хэрэгжинэ. Даатгагч өөрийн үйл ажиллагааны шинж чанар, хэмжээнээс хамаарсан эрсдэлийн удирдлагын бүтэцтэй байх шаардлагатай. Энэхүү бүтэц нь эрсдэлийн үр ашигтай удирдлага, эрсдэлийн хяналт явуулах боломж, чадавхтай байна.

2.4.5. Эрсдэлийн тайлагнал ба харилцан холбоо: Эрсдэлийн удирдлагын процессыг ил тод байлгах хамгийн чухал шалгуур, үзүүлэлтүүдийг тогтоох, эрсдэлийн удирдлага болон эрсдэл хүлээж авахтай холбоотой шийдвэрүүдийг хэрхэн гаргах талаар, мөн үнэлгээ хийх давтамжийг тусгах.

2.5. Даатгагч нь компанийн нэгдэлд багтдаг бол компанийн нэгдлийн түвшинд үнэлгээ хийх аргачлалыг багтаана.

2.6. Даатгагч нь энэ зааврыг дараа онд дагаж мөрдөх эсэх талаар, мөрдөхөөргүй бол холбогдох тайлбар, мэдээллийг өмнөх оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

### **Гурав. Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ хийх, үнэлгээний тайлан**

3.1. Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээ хийх эрсдэлийн менежертэй байх бөгөөд энэ зааврын 2.3, 2.4-т заасны дагуу үнэлгээг жилд дор хаяж нэг удаа хийж гүйцэтгэн үнэлгээний тайлан гаргана.

3.2. Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан /цаашид “үнэлгээний тайлан” гэх/-г дор хаяж энэ зааврын хавсралтад заасан үзүүлэлтийн дагуу гаргах ба уг хавсралтад нэмж үзүүлэлт оруулах боломжтой.

3.3. Даатгагчийн үнэлгээний тайланд даатгагчийн дотоод хяналтын алба нь хяналт шалгалт хийж, дүгнэлт боловсруулна.

3.4. Даатгагч үнэлгээний тайланг даатгагчийн дотоод хяналтын дүгнэлтийн хамт дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.5. Даатгагч нь өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлантай холбоотойгоор даатгагчийн бизнес төлөвлөгөө болон андеррайтинг, давхар даатгал, хөрөнгийн удирдлагатай холбогдох төлөвлөгөө, баримт бичигт өөрчлөлт оруулах

тохиолдолд энэ талаар үнэлгээний тайланд заавал тусгаж, эдгээр баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулна.

3.6. Даатгагч макро, микро эдийн засгийн хүчин зүйл, даатгагчийн бизнесийн стратеги болон бусад гадаад, дотоод орчны өөрчлөлтөөс үүдэн даатгагчид үүсэж болзошгүй эрсдэлийг стресс тест, эмзэг байдлын шинжилгээ, урвуу стресс тест болон бусад шинжилгээний арга аргачлалыг ашиглан дүгнэлт хийсэн байх шаардлагатай.

3.7. Даатгагч нь төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон даатгалын нөөц сангийн хүрээнд зохицуулагчаас тавьж буй хөрөнгийн шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, холбогдох шинжилгээг хийж ажиллах ба үүнд дараах зүйлсийг заавал шалгана:

3.7.1. Даатгагчийн эрсдэлийн багцад орж болзошгүй ирээдүйн материаллаг өөрчлөлт.

3.7.2. Даатгагчийн бизнес төлөвлөлтийн бүхий л шатыг санхүүжүүлэх хөрөнгийн чанар, тоо хэмжээ.

3.7.3. Даатгагчийн хөрөнгийн төрлийн бүрдэл, үүнд бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах төлбөр тооцоо, хугацаанд гарах өөрчлөлт нь хэрхэн нөлөөлж болох талаар үнэлгээ хийх.

3.7.4. Нөөц сангийн тооцоололд тавигдах шаардлагыг даатгагч тогтмол хангаж байгаа эсэх талаарх мэдээлэл.

3.7.5. Нөөц сангийн тооцоололтой холбоотойгоор гарч болзошгүй боломжит эрсдэлийг тодорхойлох.

3.8. Даатгагч энэ зааврын 3.7-д заасан шинжилгээг хийх явцад даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт болон даатгалын нөөц санд холбогдох эрсдэл үүссэн тохиолдолд энэ талаар Хороонд нэн даруй мэдэгдэнэ.

### **Дөрөв. Хяналт, хариуцлага**

4.1. Даатгагчийн ирүүлсэн үнэлгээний аргачлал болон үнэлгээний тайлан нь Хорооноос даатгагчид хийх хяналт шалгалтын үндсэн баримт бичиг болох бөгөөд үүнтэй холбогдуулан Хороо хэдийд ч нэмэлт материал шаардаж болно.

4.2. Даатгагчийн үнэлгээний аргачлал болон үнэлгээний тайлан, тэдгээрийг боловсруулахад ашигласан мэдээллийн үнэн зөв эсэхийг даатгагч хариуцах бөгөөд тэдгээрийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Хороо зөвлөмж хүргүүлж болно.

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны даргын  
2018 оны 12 дугаар сарын ...-ны өдрийн... дүгээр тушаалаар  
баталсан “Даатгагч өөрийн эрсдэл болон төлбөрийн  
чадвараа үнэлэх заавар”-ын хавсралт

Даатгагчийн өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварын үнэлгээний тайлан

Бүлэг		Товч тайлбар
А	Ерөнхий танилцуулга	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний тайлангийн зорилго</li> <li>• Үнэлгээний тайланд тусгагдсан төлөвлөгөөний хамрах хүрээ</li> <li>• Үнэлгээний үр дүнгийн тойм</li> <li>• Даатгагчийн санхүүгийн чадавхад нөлөөлөх гол эрсдэлүүд болон тэдгээрийн нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд</li> </ul>
Б	Үнэлгээний процесс	<ul style="list-style-type: none"> <li>• Үнэлгээний процессын товч танилцуулга</li> <li>• Эрсдэлийн профайлыг удирдах бодлогуудын үр нөлөөний талаарх тайлбар болон эрсдэлийн удирдлагын гол бодлогын хураангуй</li> <li>• Үнэлгээний процесс болон суурь таамаглал(төсөөлөл)-ын хураангуй</li> <li>• Үндсэн төсөөллийн дэлгэрэнгүй болон голлох төсөөллүүдийн хоорондох харилцан хамаарал</li> </ul>
В	Стратеги ба эрсдэл даах чадвар	<ul style="list-style-type: none"> <li>• Өнөөгийн бизнес стратеги болон эрсдэл даах чадварын талаар</li> <li>• Бизнесийн стратегийн эрсдэлийн профайлд үзүүлэх нөлөөлөл</li> <li>• Стратеги, эрсдэл, хөрөнгийн хоорондын уялдаа холбоог харуулсан байх</li> </ul>
Г	Эрсдэлд өртөх байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Тодорхойлогдсон эрсдэлийг хэрхэн давах талаарх одоогийн эрсдэлийн профайлын үнэлгээ болон эрсдэл даах чадварын тайлан</li> <li>• Эдийн засгийн хөрөнгө болон зохицуулалтын хөрөнгийн хяналтын хүрээнд тооцоолох боломжгүй эрсдлийг үнэлэх (тухайлбал группын, нэр хүндийн болон шинээр гарч ирж болзошгүй эрсдэл)</li> <li>• Гол эрсдэлийг бууруулахад тавигдах хяналтын үр дагаварын үнэлэлт</li> <li>• Сүүлийн тайлангаас хойш эрсдэл даах чадварын тооцоололд гарсан алдаа болон эрсдэлийн стратеги, хөрөнгөд үзүүлэх аливаа нөлөөлөл байгаа эсэх</li> </ul>
Д	Бизнес төлөвлөгөө болон стресс тест хийх	<ul style="list-style-type: none"> <li>• Стресс тест, эмзэг байдлын шинжилгээний хураангуй</li> <li>• Таамаглалд авч үзсэн үзүүлэлтүүдийн тайлбар болон стресс тестийн бүтэц, түүнийг сонгосон үндэслэл</li> <li>• Төрөл бүрийн нөхцөлөөр тооцоолсон боломжит эрсдэл, хөрөнгө, төлбөрийн чадварын профайл</li> <li>• Үр дүнгийн чанар (хэрэв байгаа бол)</li> </ul>
Е	Хөрөнгийн шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>• Шаардлагатай хөрөнгийг тодорхойлох аргачлалын тойм</li> <li>• Учирсан бодит болон болзошгүй эрсдэлд тулгуурласан шаардлагатай хөрөнгийн тооцоолол</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Санхүү, эдийн засаг, өөрийн хөрөнгийн зохистой байдлын өөрчлөлтийн гол нөлөө үзүүлэгч хүчин зүйлийн шинжилгээ</li> </ul>
Ё	Төлбөрийн чадварын тооцоолол	<ul style="list-style-type: none"> <li>• Өнөөгийн болон ирээдүйн төсөөлөл дээр үндэслэсэн шаардлагатай хөрөнгөд нийцүүлсэн санхүүгийн үнэлгээ</li> <li>• Төлөвлөсөн санхүүжилт нь ирээдүйн хэрэгцээтэй хөрөнгийг хангаж чадахгүй тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөө, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа</li> <li>• Шаардлагатай тохиолдолд болзошгүй эрсдэлийн дараах үйл явдалд зориулсан нэмэлт санхүүжилтийг олох боломж (жишээ нь, толгой компанийн зүгээс)</li> <li>• Хөрөнгийн үр ашигтай байдал болон чанарт үнэлгээ өгөх</li> </ul>
Ж	Баталгаатай байдал	<ul style="list-style-type: none"> <li>• Өмнөх жилийн төсөөллийг бодит тохиолдолтой харьцуулалт хийж үнэлэлт, дүгнэлт өгөх (хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг оруулаад)</li> <li>• Өмнөх үнэлгээний тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу удирдлагаас авсан арга хэмжээний талаар</li> <li>• Үнэлгээнд өгсөн хөндлөнгийн үнэлгээ (хэрвээ байгаа бол)</li> <li>• Хязгаарлалт ба хамаарал</li> </ul>
З	Хавсралт, тайлбар	Стресс тестийн дэлгэрэнгүй төсөөлөл